

## НИЙСЛЭЛИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Нэг. Байгууллагын түүх

Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь Ардын Эрүүлийг Хамгаалах яамны сайдын 1930 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 85 тоот тушаалаар Улсын клиникийн төв эмнэлгээс тусгаарлан 3 бага эмч, 3 асрагч, түргэн тусламжийн нэг морин тэрэгчинтэйгээр бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд түүхэнд энэ өдрийг тус төвийн тулгын чулуу тавигдсан өдөр гэж үздэг.

Түргэн тусламжийн төв нь өдөр, шөнийн 24 цагт байнгын бэлэн байдалд байж эмнэлгийн яаралтай тусламжийг цаг алдалгүй, үнэ төлбөргүй үзүүлдэг цорын ганц “Тусгай төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг” юм.

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 72 тоот тогтоол гарч Хотын түргэн тусламжийн станцад Нийслэлийн түргэн тусламжийн автобааз болон алсын түргэн тусламжийн үйлчилгээг нэгтгэн **“Яаралтай тусламжийн төв”** болгон өөрчлөн зохион байгуулсан. Ингэснээр тус төв нь улсын хэмжээнд түргэн тусламжийн үйлчилгээг боловсронгуй болгох, одоо, ирээдүйн хөгжлийн зорилтыг тодорхойлох, эмч, мэргэжилтнүүдийг системтэй бэлтгэх, удирдлага зохион байгуулалт арга зүйн төв болон өргөжсөн.

Яаралтай тусламжийн төв нь зохион байгуулалтын хувьд захиргаа аж ахуйн, санхүү, хүн хүч, яаралтай тусламж-эмнэлэг үйлчилгээ, эмчилгээний чанарын хяналт-статистик мэдээлэл, авто аж ахуй хангамж, ойрын болон алсын дуудлага хүлээн авч гаргадаг диспетчер, холбоо ашиглалтын албад 240 гаруй ажиллагсадтай, их эмч 72, эмнэлгийн дунд мэргэжилтэн 20 жолооч, техникийн ажилтан 98, захиргаа, санхүү, аж ахуйн ажилтан тэрбум төгрөгийн төсөвтэй ажиллаж байна.

Тус төв нь **“Эмнэлгийн яаралтай тусламж, авто аж ахуй-хангамж үйлчилгээ, алсын түргэн тусламж”** гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Яаралтай тусламжийн төвийн хөгжлийн түүхийг хэд хэдэн үе шат болгон үздэг. Үүнд:

1. 1930-1950 он түргэн тусламжийн үүсэл хөгжлийн эхлэл үе *БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1925 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Улаанбаатар хотын төв больницын эмч нар өвчтэй хүмүүсийг гэрт нь очиж үзэх болсон.*

Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний хэсэг

Зүрх судас-эрчимт эмчилгээ, осол-гэмтэл, мэдрэл, мэс засал, төрөх-эмэгтэйчүүд зэрэг төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан нарийн мэргэжлийн эмч, сувилагч, жолооч нарын багууд өвчтний дуудлаганд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэнээр яаралтай тусламжийн чанар хүртээмж сайжирч, үйлчилгээний нэр төрөл жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Зүрх, судас, сэхээн амьдруулах эрчит эмчилгээний иж бүрэн тоноглогдсон автомашинаар үйлчилсэнээр эмнэлэг үйлчилгээнд дэвшил гарсан.

Түргэн тусламжийн төв нь хоногт насанд хүрэгчдийн 480-520, хүүхдийн 75-120 дуудлага хүлээн авч жилд дунджаар 140,0 мянга гаруй дуудлаганд үйлчилж байна.

- Мэдээлэл шуурхай удирдлагын төв

Эмнэлгийн шуурхай тусламжийн алба нь дуудлага хүлээн авах, шилжүүлэх, төвлөрөл ихтэй гудамж, талбайд байрлуулсан 17 камеруудыг хянах, нарийвчилсан статистик мэдээллээр хангах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, онцгой байдлын үед удирдлагын түвшний хурал зохион байгуулах зэрэг холбоо, хяналт, мэдээллийн бүхий л үйл ажиллагааг хянах, удирдан чиглүүлэх, бүртгэн авах боломж бий боллоо. Дуудлага хүлээн авах үйл ажиллагааг бүрэн автоматжуулан (313,ОР5,ТГС8 технологийн тусламжтайгаар авто объектуудын байршил, хөдөлгөөнийг шууд хянах, удирдлагаар хангах боломжтой болсон. Дуудлагын диспетчер, эмч нарын үйл ажиллагааг хянах **“компьютер-мэдээлэл-хяналтын сан”** шинээр байгуулсан. Эмч нарын дуудлагын хуудсыг цахим хэлбэрт шилжүүлснээр статистик мэдээ боловсронгуй болж мэдээлэл технологийн дэвшил гарган ажиллаж байна

- Авто аж ахуй хангамж үйлчилгээний хэсэг нь:

Нийслэлийн ард иргэдийн түргэн тусламж, үйлчилгээний зориулалтаар хоногт 24-26 автомашин гарч үйлчилдэг.

Түргэн тусламжийн төвийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний өвөрмөц стандартыг шинэчлэн өөрчлөх талаар 2009-2013 он хүртэлх хугацааны стратеги төлөвлөгөө

боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна

1940 оны 05 сард Төв эмнэлгээс түргэн тусламжийн тасаг салган Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах хэлтсийн харьяанд анхны биеэ даасан түргэн тусламжийн станцыг байгуулав.

1947 онд нээгдсэн Халдварт өвчнийг эмчлэх больницын дэргэд Халдвартын түргэн тусламжийн станцыг байгуулав. Мөн ондоо Хүүхдийн түргэн тусламжийн станцын дүрмийг боловсруулан гаргасан.

*2. 1950-1970 он Түргэн тусламжийн станцын материаллаг бааз өргөжиж эмч, мэргэжилтэн, жолооч, техникийн ажилчид зэрэг боловсон хүчнээр хангагдсан үе*

1954 оноос түргэн тусламжинд зориулсан тоногтой ПАЗ-650 машиныг үйлчилгээнд хэрэглэх болсны дээр 1954 онд Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах хэлтсийн даргын тушаалаар түргэн тусламжийн станц 20 гаруй орон тоотой 7 машинтай болж нэг ээлжинд 3 бага эмч, машинтайгаар ажиллаж хоногт 35-40 орчим дуудлаганд үйлчилдэг болсон.

1960-аад оноос халдварт өвчинд үйлчлэх тусламжийн үйлчилгээг тусгайлан АЦХС станцын харьяанд ажиллуулах болсон байна.

1966 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлөөс **“Эмнэлгийн түргэн тусламжийн ажлыг сайжруулах арга замын тухай” 116 дугаар тогтоол** гаргаж 16 хүртлэх насны хүүхдэд үйлчлэх түргэн тусламжийг дүүргийн эмнэлгүүдэд шилжүүлэн хүүхдийн их эмч үйлчлэх болсон.

1969 онд Эрүүлийг хамгаалах яамны харьяанд түргэн тусламжийн авто машинуудын засвар үйлчилгээний станцыг байгуулалаа.

*3. 1970-1990 Түргэн тусламжийн үйлчилгээнд төрөлжсөн мэргэжлийн тусламжийн бригадын үйлчилгээ нэвтэрсэн үе*

1970 оноос Түргэн тусламжийн дуудлаганд хөдөө орон нутгаас онгоцоор хүнд өвчтөнүүдэд газар дээр нь тусламж үзүүлж тээвэрлэх болсон юм.

1974 онд Хотын Түргэн тусламжийн одоогийн барилгыг автомашины гаражийн хамт барьж 2 талын радио богино долгионы станцтай болжээ.

1980 онд Аптан гадас одонгоор шагнагдаж Нийслэлийн тэргүүний байгууллага болсон.

1981 онд Хотын АДХГЗ-ны 28 дугаар тогтоолоор Хотын түргэн тусламжинд үйлчилдэг бүх автомашиныг нэгтгэн Түргэн тусламжийн станцаас салгаж Хотын түргэн тусламжийн авто баазыг Эрүүлийг хамгаалах газрын харъяанд байгуулав.

1986 онд Түргэн тусламжийн үйлчилгээг хөдөлмөрчдөд ойртуулах зорилгоор Октябрийн районд Түргэн тусламжийн салбар станц байгуулж 1996 он хүртэл ажиллуулсан.

1989 онд Түргэн тусламжийн үйлчилгээ их эмчийн үйлчилгээнд бүрэн шилжсэн.

*4. 1990-2000 он Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнтэй уялдуулан түргэн тусламжийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон шинэчилж, орчин үеийн оношлогоо-эмчилгээний багаж хэрэгслээр хангагдаж эхэлсэн үе*

1992 онд Засгийн газрын 54 дүгээр тогтоолоор Түргэн тусламжийн авто баазыг Түргэн тусламжийн станцтай нэгтгэн Хотын түргэн тусламжийн төв болгон зохион байгуулагдсан.

1996 онд ЭМНХЯ-ны Сайдын 192 дугаар тушаалаар Түргэн тусламжийн авто баазыг ЭМЯ-ны авто баазтай нэгтгэн Нийслэлийн Түргэн тусламжийн авто бааз болгон зохион байгууллаа.

1999 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн Газрын 72 дугаар тогтоолоор Хотын Түргэн тусламжийн төвд Нийслэлийн Түргэн тусламжийн авто баазыг нэгтгэн **"Яаралтай Тусламжийн Төв"** болгон зохион байгуулснаар эмч, жолооч нарын үүрэг зорилго нэгдэж ажлын уялдаа холбоо сайжирсан.

2000 онд дуудлагын эмч нарын оношлогоо эмчилгээний стандартчилалыг анх удаа боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн юм.

*5. 2000-2010 эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлага хүлээн авах, гаргах, мэдээ, мэдээлэлийг автоматжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын эхлэл тавигдсан үе*

2005 оноос эхпэн компьютерийн мэдээллийн сүлжээг нэвтрүүлсэн.

2010 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 1,8 тэрбумын хөрөнгө оруулалтаар Баянзүрх болон Сонгино хайрхан дүүрэгт 2 салбар төв баригдсан.

2010 оны 06 сарын 25-наас **"Цахим эмнэлэг"** хөтөлбөр бүрэн хэрэгжсэн.

2010 оны 10 сарын 21-нд "Түргэн тусламжийн түүхт 80 жил"-ийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.

2013 оны 01 сарын 01-нээс Сонгино хайрхан, Баянзүрх дүүргийн хүүхдийн

түргэн тусламжийн үйлчилгээг авч эхэлсэн.

Тус төв нь зохион байгуулалтын хувьд эмнэлэг үйлчилгээ, авто аж ахуй, санхүү, үйлчилгээ гэсэн албадтайгаар дараах үйл ажиллагааг явуулж байна.

Тус төвийн хэмжээнд дуудлагын тоог цөөрүүлэх аргачлал “Цахим 103” интернэт кабинет компьютерын дотоод сүлжээ, автомашины парк шинэчлэл зэрэг төслүүдийг хэрэгжүүлээд байна.

Алсын дуудлага үйлчилгээ нь 24 цагаар ажиллаж, жилдээ 21 аймаг, хотоос 230-260 дуудлага хүлээн авч, клиникийн нэгдсэн эмнэлгүүдийн өндөр нарийн мэргэжлийн эмч нарыг машин, онгоц, гал тэргээр явуулж, газар дээр тусламж үзүүлж байна.

Яаралтай тусламжийн төвийн “ **Эмнэлэг үйлчилгээг сайжруулахад 2010 он хүртлэх хугацааны хөтөлбөр**”-ийг боловсруулж албаныхаа бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагааны чиглэлд үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг бий болгосон.

103-ын дуудлагын диспетчерүүдийн үйл ажиллагаа 100% нь их эмчийн үйлчилгээнд шилжсэн.

Тус төвийн авто аж ахуй нь 50 автомашинтай, өөрийн бие даасан авто граж, засварын цех, шатахуун түгээх станцтай бөгөөд авто бааз нь хоногт эмнэлэг-үйлчилгээ, яаралтай тусламжийн дуудлаганд 37 автомашин гарч үйлчилж байна.

### **Хоёр. Хөмрөгийн баримтын түүх**

Түргэн тусламжийн станц нь анх байгуулагдсан үеэс эхлэн бичиг хэрэг хөтлөлийн систем эхэлсэн түүхтэй боловч 1967 оноос хойшхи бичиг хэргийн заавар дүрмийн дагуу цэгцлэн хөтлөгдөж нэг өрөөнд хадгалагдаж ирсэн.

1995 онд ЭМЯ-ны автобаазыг Түргэн тусламжийн автобаазтай

1999 онд Түргэн тусламжийн авто баазын Яаралтай тусламжийн төвтэй тус тус нэгтгэж улмаар тус байгууллагуудын баримт материалуудыг архив нэгтгэн хадгалж байна.

2004 онд Түргэн тусламжийн Яаралтай төвийн захирлын 16 тоот тушаалаар байгууллагын архив, бичиг хэргийн материалыг цэгцлэн, бүртгэл тооллого явуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж доорх ажлыг хийлээ.

1962-2004 оны материалыг цэгцэлж байнга болон түр хадгалах баримт материалуудыг Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгсөн.

1. Байгууллагын архивын баримтыг хадгалах тусгай өрөө гарган засварлаж, цонх, хаалгыг бэхлэн, тавиур шкаф тавьж архивын баримтыг цэгцэлсэн.
2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган Яаралтай тусламжийн төв, ЭМЯ-ны авто баазын түр хадгалах баримтыг нэгтгэх ажлыг хийсэн.
3. Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн зааврын дагуу БНШКомиссын гишүүдээр хэлэлцүүлэн устгалын бүртгэлийг үйлдсэн.
4. Байгууллагын архивын болон бичиг хэргийн хөтлөлтийг үндсэн зааврын дагуу акт, маягтуудыг зохих журмын дагуу хөтөлж хэвшүүлэх ажлыг хийлээ.
5. Нийслэлийн Архивын газар 70 жил хадгалах 1962-2002 оны 88 ХН, байнга хадгалах 1964-2003 оны 214 ХН-ийн данс, бүртгэлийг үйлдэн хүлээлгэн өгсөн.
6. Тус төвийн өөрийн байранд түр хадгалах 1995-2007 оны 630 ХН, гэрэл зургийн 1950-2010 оны 70 ширхэг зураг, зураг төслийн 1982 оны 2 ХН, кино дүрс бичлэгийн 2007-2010 оны 11 ХН тус бүр хадгалагдаж байна.

Тус байгууллага нь Нийслэлийн Архивын газрын хөмрөг үүсгэгч 127 дугаар газар бөгөөд данс 1-ийг үргэлжлүүлэн данс 2-ын баримтыг цэгцлэх ажил хийгдээд байна.

Тус байгууллага нь 2014 онд 2004-2013 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу Нийслэлийн Архивын газрын Зааварлагч-арга зүйч О.Жүгдэрнамжилаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1995-2013 оны нийт 626 гаруй баримтад 2014 оны 03 дугаар сарын 03-наас 2014 оны 05 дугаар сарын 05-нийг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүний үр дүнд байнга хадгалах 1980-2009 оны 121 ХН, 70 жил хадгалах 52 ХН, дуу дүрс бичлэгийн 1993-2011 оны 10 ХН, цахим гэрэл зураг 3 ХН, гэрэл зургийн цомгийн 1930-2010 оны 6 ХН-ийн данс, бүртгэлийг тус тус үйлдсэн.

Мөн байгууллага дээр хадгалагдаж байгаа 2004 оноос хойшхи байнга хадгалагдах байгууллагын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, хурлын тэмдэглэл, төсвийн гүйцэтгэл, гэрээ, санхүүгийн баримтыг түрийн бүртгэлд, 70 жил хадгалах цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, ажилчдын хувийн хэрэг зэрэг хадгаламжийн нэгжийг хадгалах хугацааны заалтаар бүртгэл хийгдсэн.

2004-2013 оны байнга хадгалах 121 хадгаламж, 1995-2013 оны 70 жил хадгалах 52 хадгаламжийн нэгжийг дугаарлан бүртгэл үйлдэв. 2004-2013 оны түр хадгалах 346 хадгаламжийн нэгжийн хадгалах хугацааг нягтлан шалгаж, данс бүртгэл үйлдэн, он тус бүр дээр ач холбогдлоор нь ангилан ялгаж бүртгэл үйлдсэн.

1995- 2008 оны устгах баримтуудыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 14 хэргийн 3165 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

2004-2013 оны нийт 626 баримтанд бүртгэл үйлдсэн. Мөн 5 албадын төлөвлөгөө, биелэлт, тайланг тус тусад нь салгаж үдэж хавтаслан бүртгэсэн.

1995-2010 оны цалин, ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 70 жилд авч, баримт бичгийг нягтлан шалгаж он онд салгаж 70 жил хадгалах хэргийг бүрдүүлэн техник боловсруулалтын ажлыг хийсэн.

1995-2008 оны кассын баримт, харилцахын баримт жолоочийн тооцоо, сэлбэг, шатахуун актлагдсан машины хувийн хэрэг, эмийн зарлага, дуудлагын хуудас, өдөр тутмын мэдээ, дүүргийн мэдээ зэрэг баримтуудыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 14 хэргийн 3165 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.